

## ГАРЧИГ

<b>БҮЛЭГ 1. ОРШИЛ</b> .....	<b>3</b>
<b>БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	<b>4</b>
2.1. Төслийн нэр.....	4
2.2. Төсөл хэрэгжүүлэгч .....	4
2.3. Төслийн байршил.....	4
2.4. Уурхайн нөөц, хүчин чадал.....	6
2.5. Уурхайн дэд бүтэц .....	6
<b>БҮЛЭГ 3. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	<b>8</b>
<b>БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	<b>9</b>
<b>БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	<b>10</b>
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	10
5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт .....	13
5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	13
5.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	14
5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	14
5.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	14
5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	16
5.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	17
5.9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт .....	18
5.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт .....	19
<b>2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛСАН НИЙТ ЗАРДАЛ</b> .....	<b>23</b>
<b>ДҮГНЭЛТ</b> .....	<b>24</b>
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ</b> .....	<b>25</b>

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл .....	4
Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол .....	4
Хүснэгт 3 Барилга, байгууламжийн хийц бүтээц, эзлэх талбайн хэмжээ .....	6
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	10
Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	13
Хүснэгт 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	14
Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	16
Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт .....	17
Хүснэгт 9. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөөний биелэлт .....	18

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт .....	19
Хүснэгт 11. 2023 оны БОМТ-нд зарцуулсан нийт зардал .....	23

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Өвдөгийн худаг” нэртэй элс хайрганы ордын байршлын зураг .....	5
Зураг 2. “Гурван тахилгат оргил” ХХК-ийн MV-64000127 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн зураг .....	5
Зураг 3. Дотоод тээвэрлэлтийн замд хайрга дэвссэн байдал .....	11
Зураг 4. Уурхайн дотоод тээврийн замыг засаж хайрга дэвссэн байдал.....	11
Зураг 5. Уурхайн овоолгыг стандартын дагуу байршуулсан байдал .....	12
Зураг 6. Мод бут тарьсан байдал.....	13
Зураг 7. Галаас сэргийлэх багаж хэрэгсэл байршуулсан байдал .....	15
Зураг 9. Хөрсний агрохимийн, эрүүл ахуйн шинжилгээний дүн .....	20
Зураг 10. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн.....	21

## БҮЛЭГ 1. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Өвдөгийн худаг” нэртэй элс хайрганы ордын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

### **БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулах аргачлал:**

Тус төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“Өвдөгийн худаг” элс хайрганы ордын БОМТ-ний биелэлтийн тайланд 2023 онд нийт **4,280,000** төгрөг зарцууллаа.

## БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Гурван тахилгат оргил” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		9011504042
3	Уурхайн нэр		
	“Өвдөгийн худаг” нэртэй элс хайрганы орд ашиглах төсөл		
4	Ордын	Нийслэл/Хот/ Аймаг	Баянхонгор аймаг
5	байршил	Сум/Дүүрэг	Өлзийт сум
6	Ашигт малтмалын төрөл		Элс хайрга
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		MV-64000127
8	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар хот
9		Сум/Дүүрэг	Сүхбаатар дүүрэг
10		Баг/Хороо	9-р хороо, Их тойруу, 60, 25 тоот.
11	Захирлын хаяг	Нэр	Захирал Д.Чойжилсүрэн
12		Гар утас	976-88112742

### 2.1. Төслийн нэр

“Өвдөгийн худаг” нэртэй элс хайрганы орд ашиглах төсөл

### 2.2. Төсөл хэрэгжүүлэгч


“Гурван тахилгат оргил” ХХК

### 2.3. Төслийн байршил


“Гурван тахилгат оргил” ХХК-ны MV-64000127 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Өвдөгийн худаг” нэртэй талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун тийш 630 км Баянхонгор аймгийн төвөөс зүүн урагш 10 км, Өлзийт сумын төвөөс баруун хойш 8 км зайтай оршдог.

### Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	100	46	51.88	46	06	50.79
2	100	46	35.19	46	06	50.79
3	100	46	35.19	46	07	13.71
4	100	46	51.88	46	07	13.71



Зураг 1. “Өвдөгийн худаг” нэртэй элс хайрганы ордын байршлын зураг



Зураг 2. “Гурван тахилгат оргил” ХХК-ийн MV-64000127 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн зураг

#### 2.4. Уурхайн нөөц, хүчин чадал

**Уурхайн нөөц:** Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт орших “Өвдөгийн худаг” элс хайрганы ордод 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан дахь элс хайрганы ордын нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэргээр 2,386.46 мян.тн-оор үүнээс элс 1,226.64 мян.тн-оор, хайрга 1,159.82 мян.тн-оор Ашигт малтмал газрын тосны газрын 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Н/06 тушаалаар ордын нөөцийг батлуулсан.

**Уурхайн хүчин чадал:** Тус орд нь жилд 60.0 м<sup>3</sup> элс, хайрга олборлох хүчин чадалтай бөгөөд үйлдвэрлэлийн нөөцийг 8 жил ашиглахаар төлөвлөсөн байна.

#### 2.5. Уурхайн дэд бүтэц

**Барилга байгууламж:** Уурхайгаас уурхайн кемп 0.2 км, засвар үйлчилгээний төв 0.05 км зайд тус тус байрлах бөгөөд нийт 0.2 га талбайг эзлэн байрлана. Хүснэгт 3-т “Гурван тахилгат оргил” ХХК-ийн Өвдөгийн худагийн уурхайд баригдах барилга, байгууламжуудын хийц бүтээц, талбайн хэмжээг тусгалаа.

*Хүснэгт 3 Барилга, байгууламжийн хийц бүтээц, эзлэх талбайн хэмжээ*

№	Барилгын нэр	Хэмжих нэгж	Хэмжээ
<b>Хотхон</b>			
1	Уурхайн захиргааны байр	м <sup>2</sup>	30.0
2	Цайны газар	м <sup>2</sup>	80.0
3	Халуун ус болон угаалга	м <sup>2</sup>	40.0
<b>Ил уурхай</b>			
4	Уурхайн шалган шинжлэх газар	м <sup>2</sup>	12
5	Сэлбэгийн агуулах	м <sup>2</sup>	28.4
6	Харуулын байр	м <sup>2</sup>	4x3

**Уурхайн тосгон:** Уурхайн тосгон нь уурхайн захиргааны байр, ажилчдын цайны газар, угаалга, халуун усны газар зэрэг барилга, байгууламжуудаас бүрдэнэ.

Баянхонгор аймгийн төвд оршин суугч ажилчдыг уурхайн амийгийн төв хоёрын хоонд зөөж байхаар тооцсон. Уурхайн тосгонд баригдах барилга, байгууламжууд нь шаардлагатай тавилга, эд хогшлоор бүрэн хангагдсан байна.

**Холбооны байгууламж:** Уурхайн тосгонд сансрын сүлжээ бүрэн барьдаг. Уурхайд экскаватор, автосамосвал, дугуйт ачигч зэрэг үндсэн тоног төхөөрөмжийн операторууд, ээлжийн дарга нар хоорондоо богино долгионы радио холбоогоор холбогдоно.

**Түлшний агуулах:** Түлшний агуулахаас тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангана. Түлшний агуулах нь 5 хоногийн нөөц буюу 5 тн түлш хадгалах багтаамжтай байна. Эдгээр нь тусдаа шахуурга болон шүүлтүүртэй байна. Түлшийг шүүж цэвэрлэсний дараа тоног төхөөрөмжүүдийг түлшээр цэнэглэнэ. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах, аянга зайлуулагч хэрэгслүүд байрлана. Түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлж автомашин цэнэглэх талбайг хатуу хучилттайгаар хийж өгнө.

**Засвар механикийн хэсгийн барилга байгууламж:** Уурхайн тоног төхөрөөмжийн засвар үйлчилгээг үйлдвэрийн талбайд байрлах засварын цехэд хийж гүйцэтгэнэ. Засварын цехэд дугуй засвар, кран, компрессорын станц зэргийг авч суурилуулна.

**Цахилгаан хангамж:** Уурхай нь гадаад цахилгаан хангамжийн хувьд 35/10 кВ-ын “Баянхонгор” дэд станцаас 10кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам татна. Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын нийт урт 0.8 км байна. Харин уурхайн дотоод цахилгаан хангамжийн хувьд уурхайн цахилгаан хэрэглэгчид нь 10/0.4 кВ-ын трансформаторын дэд станцаар дамжин дээрх шугамаар цахилгаан эрчим хчээр хангагддаг байна.

**Усан хангамж:** Төсөл хэрэгжүүлэгч “Гурван тахилгат оргил” ХХК нь унд ахуйн ус, зам талбайн тоосжилт дарах усыг 43.0 км зайд орших гүний худгаас зөөврөөр хангахаар төлөвлөсөн байна.

### **БҮЛЭГ 3. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

“Гурван тахилгат оргил” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

#### **Тухайн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга**

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Өвдөгийн худаг” нэртэй элс хайрганы ордын үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

“Гурван тахилгат оргил” ХХК нь 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу сөрөг нөлөөллийг бууруулах ажлууд болох тоосжилт үүсэх үед усалгаа, өнгөн хөрсний овоолго, замыг тогтмол нэг маршрутаар явуулах, замын тэмдэг тэмдэглэгээ, ШТМ-ын зориулалтын сав байршуулах, дүйцүүлэн хамгаалах ажлыг орон нутагаас авсан саналын дагуу хийх, хог тээвэрлэлтийн гэрээ байгуулах, хог хаягдлын цэгийг хашаажуулах, хөрс, усны шинжилгээ хийх, галаас хамгаалах багаж хэрэгсэл, галаас сэргийлэх самбар тэмдгийг шаардлагатай газруудад байршуулах, хөдөлмөр хамгааллын сургалт зохион байгуулах, жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах, ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.



#### БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

##### *Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:*

- Замын хөдөлгөөн, тэсэлгээ, хөрс хуулалт, тээвэрлэлтээс үүдэлтэй агаарын тоосжилт, дизель түлшээр ажилладаг машин механизм тоног төхөөрөмж,
- Тэсэлгээнээс үүссэн тоосжилт, дуу чимээ,
- Хог хаягдлаас үүсэх үнэр зэрэг болно.

##### *Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл:*

- Уурхайн олборлолтын улмаас газрын хэвлий эвдрэлд орох,
- Шимт хөрсний овоолго үүсгэхэд түүнд хөрс, ургамал дарагдах,
- ШТС, тэсрэх материалын агуулах зэрэг байгууламж барихад хөрс, ургамал эвдрэлд орох,
- Уурхайн хөрс элс хайрга тээвэрлэлтийн улмаас эвдрэх талхлагдах,
- Ахуйн хог хаягдал хөрсөнд биологийн бохирдол үүсгэх,
- Аюултай хог хаягдал нь хөрсөнд удаан хугацаанд хадгалагдах бөгөөд хоруу чанар нь хөрсөн орчинд сөрөг нөлөөлөл үүсгэх эх үүсвэр болно.

##### *Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:*

- Газрын доорх усны нөөц хомсдох,
- Шатах, тослох материал асгарч тунадас болон үерийн усаар угаагдан усан орчинг бохирдуулах.

##### *Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:*

- Олборлолт хийх, хөрс хуулах, овоолго хийх, барилга байгууламж барих, техник хэрэгсэл явах зам тавих, кемп барьсны улмаас эдгээр үйл ажиллагаанд өртсөн талбайн амьтны аймаг, ялангуяа мэрэгчид, шавж, мөлхөгчид устаж үгүй болж тэдгээрийн амьдрах орчин байхгүй болно.
- Тээврийн хэрэгсэл, тэсэлгээний үеийн дуу чимээнээс хүн амьтан үргэж, дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх.

##### *Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:*

- Төслийн хугацаанд уурхайн нарийн мэргэжил шаардагдахгүй ажилд орон нутгийн иргэдээс ажиллуулах ба цөөн хэдэн хүнийг ажлын байраар хангах бөгөөд олборлолтын хугацаанд нутгийн иргэдээс өргөн хэрэглээний бараа, хүнсний тодорхой бүтээгдэхүүн (мах, цагаан идээ, гурил, будаа мөн ариун цэврийн бүтээгдэхүүнүүд г.м) худалдан авах зэргээр бага хэмжээний орлогыг нутгийн иргэдэд оруулах юм.
- Уурхайн ажлын үед ажиллах хүнд машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.
- Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал усны гэнэтийн аюул учирч болзошгүй. Үйл ажиллагааны явцдаа техникийн аюулгүй байдал алдагдах, гэнэтийн осол гарснаас ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх аюул үүснэ.

**БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНЕТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

*Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2023 он /төгрөг/
<b>Агаарын орчин</b>			
1	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийсэн	-
2	Тээвэрлэлтийн үед гарах тоос шороог багасгах үүднээс уурхайн дотоод болон гадаад замуудад хайрга чулуу дэвсэх	Тээвэрлэлтийн үед гарах тоос шороог багасгах үүднээс уурхайн дотоод болон гадаад замуудад хайрга чулуу дэвссэн	Дотоод төлөвлөлтөөр
3	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцгэй хураах	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцгэй овоолсон	Дотоод төлөвлөлтөөр
4	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хошуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, сургалт сурталчилгаа явуулах	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хошуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангаж ажилласан.	500,000
<b>Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг</b>			
1	Төслийн эдэлбэр газраас бусад талбайн ургамлыг хамгаалах зорилгоор ажилчид болон машин техникийн хөдөлгөөнийг тогтсон маршрутын дагуу явуулах, авто зогсоолыг тэмдэгжүүлэх	Машин техникийн хөдөлгөөнийг тогтсон маршрутын дагуу явуулж, авто зогсоолыг тэмдэгжүүлсэн	Дотоод төлөвлөлтөөр
2	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтанд хяналт тавих, орчны бохирдлоос сэргийлэх	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалж, хадгалалтанд хяналт тавьж ажилласан.	-
3	Асгаралтын үед хэрэглэх багаж хэрэгслээр хангаж ажиллах.	Багаж хэрэгслээр хангасан.	-
<b>Усан орчин</b>			
1	Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх	-	-
<b>Нийт дүн</b>			<b>500,000</b>



*Зураг 3. Дотоод тээвэрлэлтийн замд хайрга дэвссэн байдал*



*Зураг 4. Уурхайн дотоод тээврийн замыг засаж хайрга дэвссэн байдал*



*Зураг 5. Уурхайн овоолгыг стандартын дагуу байршуулсан байдал*

## 5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад төслийн талбай орчмын газрын хэвлий, газрын гадарга, хөрс, гадаргын усан сүлжээ, ургамлан нөмрөгт үүсэх эвдрэлийг биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх арга хэмжээ авч, нөхөн сэргээх ажлын хэмжээ, холбогдох зардлыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, аргачлал, стандарт шаардлагын дагуу нарийвчлан тооцож тусгадаг. Иймээс “Гурван тахилгат оргил” ХХК-ний “Өвдөгийн худаг” элс, хайрганы ордыг ил уурхайн агаар ашиглах төслийн ТЭЗҮ болон технологиос шалтгаалан 2023 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх боломжгүй байна.

## 5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

*Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүлсэн арга хэмжээ	Зардал, 2023 он /төгрөг /
1	Дүйцүүлэн хамгаалах хүрээнд сум орон нутагт 50ш мод тарих	50ш мод	Сум орон нутагт мод бут тарьсан.	2,000,000
<b>Нийт</b>				<b>2,000,000</b>



*Зураг 6. Мод бут тарьсан байдал*

#### 5.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2023 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

#### 5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Гурван тахилгат оргил” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна. Үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол цехийн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулна.

#### 5.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

##### Хүснэгт 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Нийт зардал, 2023 он /төгрөг/
1	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хяналт тавьж ажилласан.	-
2	Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт	-	-
3	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөг батлуулж ажилласан.	-
4	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	-	-
5	Ашиглаж буй тэсрэх материалын хор, аюулын талаарх анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээг ажлын байранд харагдахуйц байрлалд тодоор зурж бичих	Ашиглаж буй тэсрэх материалын хор, аюулын талаарх анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээг ажлын байранд харагдахуйц байрлуулсан.	300,000
6	Ажилчдыг жилд 2 удаа эрүүл мэндийн үзлэг хамруулах	-	-
<b>Нийт</b>			<b>300,000</b>



Зураг 7. Галаас сэргийлэх багаж хэрэгсэл байршуулсан байдал



Зураг 8. Галын аюулаас сэргийлэх анхааруулах самбар

5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2023 он /төгрөг /
1	Уурхайн орчинд аюултай, дахин ашиглах, энгийн гэсэн хог хаягдлын ангилан ялгалтын савнууд байрлуулах. Савнууд нь битүүмж сайтай, орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх	Уурхайн орчинд аюултай, дахин ашиглах, энгийн гэсэн хог хаягдлын ангилан ялгалтын сав байрлуулсан.	200,000
2	Хог хаягдлын түр цэг байгуулан ариун цэврийн байгууламжийг хөрсөнд халгүй байдлаар шийдэх	-	-
3	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	-	-
4	Шингэн хаягдлыг тусгай бодис хэрэглэн задлах	-	-
5	Хогийн цэгт ариутгал халдваргүйжүүлэлт хийх	Хогийн цэгт ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.	50,000
<b>ийт дүн</b>			<b>250,000.00</b>



5.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2023 он /төгрөг /
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх	Байгаль орчныг удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн.	-
2	Байгаль орчныг хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар жилд 2 удаа сургалт, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	-	-
3	Байгаль хамгаалахад сум багийн холбогдох ажилтнуудын оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	-	-
4	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
5	Бүх ажиллагсадыг жилд 1 удаа нарийн мэргэжлийн эмч нарт хамруулж байх	-	-
6	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах сургалт зохион байгуулах, галын аюулгүй ажиллагааны талаар дүүргийн ГТТХХэлтэстэй хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзүүлэх сургууль хийх	-	-
7	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгасан.	-
8	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангасан.	500,000
9	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгслийг байршуулсан.	100,000
10	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийлгэх	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийлгэсэн. Дүгнэлтийг хавсралтаар оруулав.	Мэргэжлийн байгууллагатай тохиролцсоноор
<b>Нийт дүн</b>			<b>600,000</b>

### 5.9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт


*Хүснэгт 9. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөөний биелэлт*

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Баянхонгор аймаг	Орон нутгийн байгаль орчны газар	БОМТ болон Хяналт шинжилгээний гүйцэтгэх тайлагнах	БОМТ-ийн 2023 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ны өдрийн дотор	БОМТ болон, БОМТ-ний биелэлтийн тайланг хянуулахаар ажиллаж байна.
	БОАЖЯ-ны ХБОБНУГ	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх			
Төрийн захиргааны төв байгууллага	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр болон Файл хэлбэрээр	2024 оны БОМТ	12-р сарын 01-ны өдрийн дотор	


5.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт

№	Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2023 он /төгрөг/
<b>Агаарын орчин</b>				
1	Агаарын тоосны шинжилгээ, дуу чимээ	Ил уурхай орчмоос	Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний дүнг хавсралтаар орууллаа.	480,000
<b>Хөрсөн бүрхэвч</b>				
1	Хөрсний химийн үзүүлэлт (pH, EC <sub>2.5</sub> dS/m, P <sub>2</sub> O <sub>5</sub> , K <sub>2</sub> O, CaCO <sub>3</sub> )	-Ил уурхай кемп орчим, - Уурхайн ухаш.	Хөрсний агрохимийн болон хүнд металлын дээж авч “Нарт ШҮҮН консалтинг” ХХК-ийн хөрсний лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний дүнг хавсралтаар орууллаа.	150,000
2	Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Co)	-Засварын цех, -ШТС		
<b>Нийт дүн</b>				<b>630,000</b>



### “НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан  
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10  
Утас: (976)-99176123, 99231836  
E-mail: nartconsulting@gmail.com

№ 23/09-25/1  
 ИТГЭМЖЛЭГДСЭН  
 ЛАБОРАТОРИ

Захиалагч: “Эко ногоон баялаг” ХХК  
Дээж авсан цэг: “Гурван тахилгат оргил” ХХК, Баянхонгор аймаг Өлзийт сум,  
“Өвдөгийн худаг” элс хайрганы орд (MV-64000127)  
Сорьц авсан огноо: 2023 оны 09 сар 19 өдөр  
Шинжилгээ хийсэн огноо: 09 сарын 25  
Харилцах утас:

**1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO <sub>3</sub> , %	NO <sub>3</sub> , мг/100г	Солилцох сууриуд, мг-экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca <sup>+2</sup>	Mg <sup>+2</sup>	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Дээж 1											
1	0-20	8.15	0.029	0.081	2.73	0.0	0.18	18	9	2.4	14
2	20-40	8.58	0.086	0.237	1.03	0.48	0.41	12	11	3.0	15
Дээж 2											
3	0-20	8.26	0.051	0.141	2.67	0.48	0.51	17	9	1.9	18
4	20-40	8.07	0.263	0.722	0.49	0.64	1.37	25	13	2.0	10

**1. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН**


№	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 1								
1	0-20	31.7	39.0	7.9	5.4	6.6	9.4	21.4
2	20-40	38.1	35.4	14.7	0.5	1.8	9.4	11.8
Дээж 2								
3	0-20	18.8	59.0	7.8	2.4	4.2	7.8	14.4
4	20-40	15.6	34.9	10.3	3.2	9.8	26.2	39.2

**2. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. ИГР ХӨРСӨНД**

№	Дээжний дугаар	Нянгийн тоо MNS6341:2012	Гэдэсний савханцрын титр (E.coli)MNS 5367:2004		Анаэробын (Cl.perfringens) MNS 6341:2012	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
Дээж 1						
1	Дээж 4	1.3*10 <sup>5</sup>	0.1	2	0.1<	1


\* Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжэнд хамаарна.

Зураг 9. Хөрсний агрохимийн, эрүүл ахуйн шинжилгээний дүн



## “НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК

### ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан  
 дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10  
 Утас: (976)-99176123, 99231836  
 E-mail: nartconsulting@gmail.com

**№ 23/09-25/2**

Захиалагч: “Эко ногоон баялаг” ХХК  
 Дээж авсан цэг: “Гурван тахилгат оргил” ХХК, Баянхонгор аймаг Өлзийт сум,  
 “Өвдөгийн худаг” элс хайрганы орд (MV-64000127)

Сорьц авсан огноо: 2023 оны 09 сар 23 өдөр  
 Шинжилгээ хийсэн огноо: 09 сар 26  
 Харилцах утас:

**1. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Дээж 3	0-10	24.3	45.5	0.0	37.1	15.4	12.9
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

\*Харгалзах түвшин \* Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна.

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД: (Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.УУГАНЦЭЦЭГ, Га.СОЛОНГО  
 ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D

1

Зураг 10. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн




**MNAS**  
Accreditation  
system  
T. 88  
2025 ISO/IEC

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**  
**БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН**  
**ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzi@gmail.com](mailto:bohzi@gmail.com)

**СОРИЛТЫН ДҮН**



**БАЙГАЛЬ**  
Орчин хэмжээний төв лаборатори

Дугаар он/№	2023/A-167
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Гурван тахилгат оргил” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхшиг агаарын хэсэг
Дээжийн тоо, төрөл	: 4 агаар, 4 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2023.07.01
Дээжийн тодорхойлолт	: Баянхонгор аймаг, Өлзийт сум Элс хайрганы орд
Шинжилгээний аргын стандарт	: MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021, CA3 A07-2016
Шинжилсэн огноо	: 2023.07.03
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн :	

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м <sup>3</sup>	Азотын давхар исэл мг/м <sup>3</sup>	Нийт Тоос /TSP/ мг/м <sup>3</sup>	Дуу чимээ /ДБА/
1	Ажилчдын кемп	VI/26	11:30	0.010	0.021	0.240	40
2	Засвар орчмоос	VI/26	12:00	0.012	0.023	0.220	65
3	Технологийн зам карьер орчимд	VI/26	12:40	0.013	0.028	0.260	70
4	Бутлуурын орчимд	VI/26	13:15	0.007	0.027	0.140	60
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:		Д.Түмэндэлгэр
Хянаж баталгаажуулсан Чанарын менежер:		Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

Зураг 11. Агаарын шинжилгээний дүн

**2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛСАН  
НИЙТ ЗАРДАЛ**

“Турван тахилгат оргил” ХХК-ийн 2023 оны БОМТ-ний биелэлтийн тайланг БОНХЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

2023 онд БОМТ-нд нийт **4,280,000** төгрөг зарцуулж ажиллалаа.

*Хүснэгт 11. 2023 оны БОМТ-нд зарцуулсан нийт зардал*

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2023 он /төгрөг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	500,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	2,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	250,000
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	300,000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	600,000
9	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөөний биелэлт	-
11	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	630,000
<b>Нийт дүн</b>		<b>4,280,000</b>

### ДҮГНЭЛТ

Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт орших “Гурван тахилгат оргил” ХХК-ийн “Өвдөгийн худаг” нэртэй элс хайрганы ордын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу биелэлтийн тайланг боловсруулж дараах дүгнэлтэд хүрлээ.

“Гурван тахилгат оргил” ХХК-ийн 2023 оны БОМТ-ний биелэлтийн тайланг БОНХЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Уг төслийн явцад байгаль экологийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг мөрдлөг болгон ажиллаж, 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ажилласан.

“Өвдөгийн худаг” элс хайрганы ордын БОМТ-ний биелэлтийн тайланд 2023 онд нийт **4,280,000** төгрөг зарцууллаа.



### АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014
7. Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт орших “Өвдөгийн худаг” элс хайрганы ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2022 он
8. Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт орших “Өвдөгийн худаг” элс хайрганы ордыг ил аргаар ашиглах төслийн БОМТ, 2023 он
9. <http://www.legalinfo.mn//>